



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Хушаат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/15-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Сүхбаатар сум
2022 он

Тэргүүлэх аудитор:	Ч.Энхтуяа
Утас:7036-3040	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер:	Б.Батмөнх
Утас: 7036-3036	Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
Аудитор:	З.Золбоо
Утас: 7036-2442	Цахим хаяг: Zolbooz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4. Материаллаг байдал.....	14
3.5. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	14
3.5.1. Мөнгөн хөрөнгө.....	14
3.5.2. Авлага.....	14
3.5.3. Бараа материал.....	14
3.5.4. Үндсэн хөрөнгө.....	16
3.5.5. Өр төлбөр.....	17
3.5.6. Засгийн газрын хувь оролцоо.....	18
3.5.7. Орлогын данс.....	19
3.5.8. Зарлагын данс.....	19
3.6. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга.....	19
3.6.1 Төсвийн төлөвлөлт.....	21
3.6.2 Төсвийн гүйцэтгэл.....	22
3.6.3 Нэмэлт төсөв.....	23
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	23
3.8. Аудитын гол асуудал.....	23
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	23
3.9.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	23
3.9.2. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт.....	24
3.10. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	25
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	26
4. Аудитын илрүүлэлт.....	26
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	30

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТ	Соёлын төв
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМТ	Эрүүл мэндийн төв



ХУШААТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Н. ПҮРЭВБАТ ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.25 № СЭА-2022/15-НА-СТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хушаат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хушаат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

СЭА-2022/15/-НА-СТА-ТТЗ

3

018020406

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	347,712.30	433,327.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	78,019.00	180,414.20
33	АВЛАГА	193,285.70	178,911.10
35	БАРАА МАТЕРИАЛ	76,407.70	74,002.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,411,067.10	3,342,561.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,411,067.10	3,342,561.80
39200	Биет хөрөнгө	3,244,531.50	3,176,026.20
39300	Биет бус хөрөнгө	166,535.60	166,535.60
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,758,779.40	3,775,889.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	14,016.60	6,790.70
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,016.60	6,790.70
41300	Өглөг	14,016.60	6,790.70
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,744,762.80	3,769,098.90
51	Засгийн газрын хувь оролцоо	3,744,762.80	3,769,098.90
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,254,868.70	1,254,868.70
51200	Хуримтлагдсан үр дүн	1,446,722.30	1,471,058.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,043,171.90	1,043,171.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,758,779.40	3,775,889.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,561,300.20	2,909,439.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	75,264.40	130,989.40
110	Орлогын албан татвар	40,233.70	37,183.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	40,233.70	37,183.80
113	Хөрөнгийн албан татвар	1,296.00	64,640.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж	33,734.70	29,165.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	213,634.60	208,726.70
120	Нийтлэг татварын бус орлого	213,634.60	208,726.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,272,401.20	2,569,723.40
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,586,897.20	2,793,090.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,586,897.20	2,793,090.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,920,271.20	2,057,248.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,075,967.80	1,163,861.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,828.20	149,095.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	195,874.90	199,427.50
2104	Хангамж, бараа материалын зардал	53,443.90	67,856.00
2105	Нормативт зардал	69,173.50	108,436.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,923.80	26,236.40
2107	Томилолт, зочны зардал	3,007.00	3,195.90

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,890.70	26,157.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	336,161.50	312,982.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	666,626.00	735,842.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(25,597.00)	116,348.70
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	105,389.70	92,012.60
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(130,986.60)	24,336.10

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,428,012.90	2,768,011.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	75,264.40	130,989.40
110	Орлогын албан татвар	40,233.70	37,183.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	40,233.70	37,183.80
113	Хөрөнгийн албан татвар	1,296.00	64,640.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж	33,734.70	29,165.40
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,566.40	5,787.20
1181	Газрын төлбөр	9,807.80	10,151.10
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	15,360.40	13,227.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,907.90	66,231.30
120	Нийтлэг татварын бус орлого	47,907.90	66,231.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,304,840.60	2,570,790.90
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,294,607.60	2,539,786.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,294,607.60	2,539,786.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,606,258.40	1,801,676.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,078,757.80	1,165,527.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,334.90	149,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	195,874.90	199,527.50
2104	Хангамж, бараа материалын зардал	52,276.30	63,189.80
2105	Нормативт зардал	52,886.40	98,371.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,589.50	41,565.30
2107	Томилолт, зочны зардал	3,007.00	3,195.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,405.90	26,303.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,125.80	54,296.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	688,349.20	738,109.90
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	133,405.30	228,224.80
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	103,352.30	125,829.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	103,352.30	125,829.60
2200	Дотоод эх үүсвэрээр	103,352.30	125,829.60

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(103,352.30)	(125,829.60)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(385.00)	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	385.00	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	29,668.00	102,395.30
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	48,351.00	78,019.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	78,019.00	180,414.20

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,875,749.50	-	3,875,749.50
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,875,749.50	-	3,875,749.50
4	Тайлант үеийн үр дүн	(130,986.60)	-	(130,986.60)
5	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,744,762.80	-	3,744,762.80
6	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,744,762.80	-	3,744,762.80
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,744,762.80	-	3,744,762.80
9	Тайлант үеийн үр дүн	24,336.10	-	24,336.10
10	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,769,098.90	-	3,769,098.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,017,040.60	1,824,130.37	192,910.23	90.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,801,251.00	1,739,504.39	61,746.61	96.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,784,381.20	1,723,226.55	61,154.65	96.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,160,640.10	1,148,397.65	12,242.45	98.95
210101	Үндсэн цалин	836,465.00	695,414.09	141,050.91	83.14
210102	Нэмэгдэл	240,417.80	370,428.92	(130,011.12)	154.08
210104	Урамшуулал	59,213.80	58,308.33	905.47	98.47
210105	Гэрээт ажлын хөлс	24,543.50	24,246.31	297.19	98.79

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	155,972.20	147,556.19	8,416.01	94.60
210201	Тэтгэврийн даатгал	108,968.30	103,279.47	5,688.83	94.78
210202	Тэтгэмжийн даатгал	11,751.10	11,834.37	(83.27)	100.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,400.80	9,166.36	234.44	97.51
210204	Ажилгүйдлийн даатгал	2,350.10	2,341.40	8.70	99.63
210205	Эрүүл мэндийн даатгал	23,501.90	20,934.58	2,567.32	89.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	203,199.80	199,527.54	3,672.26	98.19
210301	Гэрэл, цахилгаан	20,590.20	16,918.04	3,672.16	82.17
210302	Түлш, халаалт	178,738.10	178,738.10	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	3,871.50	3,871.40	0.10	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	56,769.70	56,726.20	43.50	99.92
210401	Бичиг хэрэг	8,430.00	8,386.50	43.50	99.48
210402	Тээвэр, шатахуун	34,417.10	34,417.10	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,831.20	4,831.20	-	100.00
210404	Ном, хэвлэл	264.60	264.60	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,565.10	1,565.10	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,261.70	7,261.70	-	100.00
2105	Нормативт зардал	60,625.10	45,269.64	15,355.46	74.67
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,442.90	11,938.57	9,504.33	55.68
210502	Хоол, хүнс	36,214.20	30,363.07	5,851.13	83.84
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,968.00	2,968.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	73,247.20	73,134.90	112.30	99.85
210601	Багаж, техник, хэрэгсэл	27,612.30	27,500.00	112.30	99.59
210602	Тавилга	18,819.60	18,819.60	-	100.00
210604	Урсгал засвар	26,815.30	26,815.30	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	3,241.50	2,907.90	333.60	89.71
210702	Дотоод албан томилолт	3,241.50	2,907.90	333.60	89.71
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,461.00	30,415.14	1,045.86	96.68
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,534.80	28,456.80	78.00	99.73
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,913.80	1,296.00	617.80	67.72
210803	Даатгалын үйлчилгээ	327.30	327.30	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	124.60	124.54	0.06	99.95
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	210.50	210.50	-	100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	350.00	-	350.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,224.60	19,291.40	19,933.20	49.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,561.20	16,628.00	19,933.20	45.48

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,663.40	2,663.40	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,869.80	16,277.84	591.96	96.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,869.80	16,277.84	591.96	96.49
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,969.80	15,377.84	591.96	96.29
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900.00	900.00	-	100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	92,508.10	84,625.97	7,882.13	91.48
220001	Барилга байгууламж	92,508.10	84,625.97	7,882.13	91.48
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	123,281.50	-	123,281.50	-
230001	Эргэж төлөгдөх зээл	123,281.50	-	123,281.50	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,017,040.60	1,872,161.23	144,879.37	92.82
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,080,898.90	1,080,898.90	-	100.00
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,080,898.90	1,080,898.90	-	100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	762,243.90	755,396.93	6,846.97	99.10
320001	Орон нутгийн төсвөөс	680,306.60	673,459.63	6,846.97	98.99
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	81,937.30	81,937.30	-	100.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС	20,112.30	2,539.96	17,572.34	12.63
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20,112.30	2,539.96	17,572.34	12.63
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	153,785.50	33,325.44	120,460.06	21.67
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	143,214.70	33,325.44	109,889.26	23.27
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	10,570.80	-	10,570.80	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	57,979.57	(57,979.57)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	88,616.34	(88,616.34)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	627.00	2,883.00	(2,256.00)	459.81
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.00	6.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	103.00	102.00	1.00	99.03
620001	Удирдах ажилтан	13.00	13.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	56.00	55.00	1.00	98.21
620003	Үйлчлэх ажилтан	30.00	30.00	-	100.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	103.00	102.00	1.00	99.03
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11.00	11.00	-	100.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	42.00	42.00	-	100.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	6.00	6.00	-	100.00

650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	18.00	17.00	1.00	94.44
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17.00	17.00	-	100.00
650010	Гэрээт ажилтан	4.00	4.00	-	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5.00	5.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	150,259.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	150,259.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	119,653.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,129.73
210102	Нэмэгдэл	9,087.29
210104	Урамшуулал	7,794.54
210105	Гэрээт ажлын хөлс	247.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	2,143.79
210201	Тэтгэврийн даатгал	1,474.30
210202	Тэтгэмжийн даатгал	167.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	88.00
210204	Ажилгүйдлийн даатгал	171.18
210205	Эрүүл мэндийн даатгал	242.95
2104	Хангамж, бараа материалын зардал	6,463.64
210401	Бичиг хэрэг	606.00
210402	Тээвэр, шатахуун	5,256.27
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	418.87
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22.50
2105	Нормативт зардал	53,102.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	53,102.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,923.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,023.00
210602	Тавилга	1,900.00
2107	Томилолт, зочны зардал	288.00
210702	Дотоод албан томилолт	288.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	599.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	499.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,004.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,437.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	567.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,605.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,200.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,405.67
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,891.13
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,514.53

I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	150,259.63
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	150,259.63
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	57,392.15
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	30,900.65
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	56,966.83

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хушаат сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /Хушаат сумын ТТЗ гэх/-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн зайлшгүй шаардлага үүсээгүй байхад төсөвт тодотгол хийхгүй байх, төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэж байх, автомашины шатахууны нормыг шинэчлэн тогтоох зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Золбоо гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хушаат сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хушаат сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хамтдаа хэлэлцэж хөгжлийн гарцаа нээе. Хамтдаа шийдэж иргэнээ, өрх гэрээ, орон нутгаа хөгжүүлье” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- 1 Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- 2 Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөхөөр батлагдсан,
- 3 Малын тоо толгойн албан татварын тухай хуультай холбоотойгоор 2020 онд Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 60 дугаар зүйлийн 60.2.8-д малын тоо толгойн албан татварын орлогыг зарцуулах заалт шинээр нэмэгдсэн,
- 4 Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах хэсэгт 2021 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан,
- 5 УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс

- шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- 6 Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолоор төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагыг төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан,
 - 7 Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах “Босго үнэ шинэчлэн батлах тухай” журмыг баталсан,
 - 8 Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” шинэчлэгдэн батлагдсан,
 - 9 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” шинэчлэгдэн батлагдсан,
 - 10 Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
 - 11 Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн,
 - 12 Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан гэх мэт.

Хушаат сумын ТТЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дээд шатны төсвийн захирагчаас дотоод аудит хийгдээгүй байна.

ТТЗ-ийн удирдлагын зүгээс тайлант онд хэрэгжүүлсэн дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзэж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хушаат ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу

бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 2,793,090.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон **41,896.4** мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 31,422.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 78,019.0 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 179,314.2 мянган төгрөг болж, 101,295.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	78,019.0	180,414.2	102,395.2	56.7
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Хадгаламж	-	-	-	-
Дүн	78,019.0	180,414.2	102,395.2	56.7

Эх сурвалж: Хушаат сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан 90,697.9 мянган төгрөг орон нутгийн ерөнхий орлогын дансанд, 1,100.0 мянган төгрөг ЗДТГ-ын арилжааны банкин дахь дансанд, 7,882.1 мянган төгрөг ОНХС-ийн дансанд, 80,734.2 мянган төгрөг СХС-ийн дансанд тус тус байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл **193,285.7** мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл **184,425.6** мянган төгрөг болж, 8,860.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	713.8	1,607.7	893.9
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-	-
Татаас, санхүүжилтийн авлага	5,887.1	5,514.5	(372.6)
Зээлийн хүүгийн авлага	8,028.5	7,480.8	(547.7)
Бусад авлага	41,146.7	62,401.3	21,254.6
Зээлийн авлага	137,509.4	107,421.3	(30,088.1)
Дүн	193,285.7	184,425.6	(8,860.1)

Эх сурвалж: Хушаат сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад авлага дансны үлдэгдэлд тайлагнагдсан байгууллагаас авах авлагад дараах авлагууд бүртгэлтэй байна. Үүнд:

- ЕБС-ийн 4,597.9 мянган төгрөг, соёлын төвийн 9.5 мянган төгрөг, цэцэрлэгийн 2.1 мянган төгрөгийн авлагууд.
- Орон нутгийн ерөнхий орлогын дансанд бүртгэлтэй 2006-2009 онд олгосон итгэлийн зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл 6,670.2 мянган төгрөгийн авлага,
- ЗДТГ-т бүртгэлтэй “Мянганы сорил сан”-гаас олгосон худгийн зээлийн 27,270.0 мянган төгрөгийн авлага,
- ЭМТ-ийн 2009 онд үүссэн эзэн холбогдогч нь тодорхойгүй 2,132.0 мянган төгрөгийн авлага, Мед буян ХХК-иас авах 14,750.0 мянган төгрөгийн авлага болон Дулаанхаан ЭМТ-с авах 6,969.6 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай /нийт/ 114,902.1 мянган төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- СХС-ийн зээлийн хүүгийн 7,480.8 мянган төгрөгийн авлага,
- СХС-ийн зээлийн 107,421.3 мянган төгрөгийн авлага байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулахаар шүүхэд 15, ШШГГ-т 9 зээлдэгчийн материалыг хүргүүлж, мэдэгдэх хуудас өгч ажилласан байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас дараах байгууллагууд авлагын үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Үүнд:

- ЕБС 1,830.7 мянган төгрөгийн хүнсний материалын,
- ЭМТ 1,253.1 мянган төгрөгийн ажилчидтай холбогдсон авлага.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 76,406.6 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 74,002.5 мянган төгрөг болж, 2,404.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	1,183.1	2,223.9	1,040.8
Эм боох материал	7,089.9	4,151.7	(2,938.2)
Бэлэн бүтээгдэхүүн	7,117.7	9,553.6	2,435.9
Бичиг хэргийн материал	903.4	1,253.5	350.1
Аж ахуйн материал	29,899.2	25,574.5	4,324.7
Сэлбэг хэрэгсэл	6,820.9	630.0	(6190.9)
Түлш, шатах тослох материал	-	662.8	(662.8)
Барилгын засварын материал			
Хүнсний материал	5,500.1	6,942.1	1,442.0
Бусад хангамжийн материал	17,893.3	23,010.4	5,117.1
Дүн	76,407.6	74,002.5	(2,405.1)

Эх сурвалж: Хушаат сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 317,278.4 мянган төгрөгийн материал худалдан авсан, 30,772.0 мянган төгрөгийн материал хандиваар хүлээн авсан болон 300,117.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, сумын ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэсэн 46,868.4 мянган төгрөгийн бараа материалыг ашиглагч байгууллагад шилжүүлж, 3,469.2 мянган төгрөгийн бараа материалыг акталсан байна.

Аудитын илрүүлэлт:

Дараах байгууллагууд нь бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна Үүнд:

- ИТХ нь 2,473.0 мянган төгрөгийн,
- ЗДТГ нь 21,327.4 мянган төгрөгийн,
- Соёлын төв нь 3,752.4 мянган төгрөгийн,
- ЭМТ нь 12,051.0 мянган төгрөгийн,
- Цэцэрлэг 9,469.2 мянган төгрөгийн,
- ЕБС 34,954.6 мянган төгрөгийн гэх мэт.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,012,518.6 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 4,167,567.5 мянган төгрөг болж, 155,048.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл / анхны өртгөөр /

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	2,182,083.0	2,216,340.4	34,257.4
Авто-тээврийн хэрэгсэл	253,803.1	232,803.1	(21,000.0)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	200,664.9	253,531.5	52,866.6
Тавилга, аж ахуйн эд хогшил	136,799.4	145,709.6	8,910.2
Зам, гүүрийн байгууламж	231,458.6	231,458.6	-
Бусад үндсэн хөрөнгө	264,355.2	343,078.1	78,722.9
Дуусаагүй барилга, байгууламж	484,579.0	484,579.0	-
Ном	91,432.0	92,723.8	1,291.8

Программ хангамж	850.0	850.0	-
Бусад биет бус хөрөнгө	166,493.4	166,493.4	-
Дүн	4,012,518.6	4,167,567.5	155,048.9

Эх сурвалж: Хушаат сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийн данс / анхны өртгөөр / төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 41,203.6 мянган төгрөг, хандиваар 44,085.8 мянган төгрөг, шилжүүлэн авсан 95,924.2 мянган төгрөг, нийт 181,213.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, сумын ИТХ-ын 2021 оны 07 дугаар тогтоолоор цэцэрлэг нь 5,164.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан, ЗДТГ нь ОНӨГ-ын 2017 оны 02 дугаар сард дуудлага худалдаагаар зарагдсан 21,000.0 мянган төгрөгийн автомашиныг данс бүртгэлээр хассан зэргээс буурсан байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл **14,016.6** мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл **12,305.2** мянган төгрөг болж, **1,711.4** мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	5,887.2	5,514.5	(372.7)	(6.7)
Байгууллагад төлөх өглөг	7,385.2	6,790.7	(594.5)	(8.7)
Хувь хүмүүст төлөх өглөг	744.2	-	(744.2)	-
Дүн	14,016.6	12,305.2	(1,711.4)	(13.9)

Эх сурвалж: Хушаат сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын 5,514.5 мянган төгрөг, СХС-ийн 4,960.0 мянган төгрөг, ОНХС-ийн 1,600.0 мянган төгрөг, ЭМТ-ийн 230.7 мянган төгрөг зэрэг нийт 12,305.2 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- ЭМТ нь төсвийг зохистой удирдаагүй өглөг, авлага ба төлбөрийн тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 230.7 мянган төгрөгийн байгууллагад төлөх өр төлбөр үүсгэсэн байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,744,762.9 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 3,781,404.1 мянган төгрөг болж, 36,641.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6 Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,254,868.7	1,254,868.7	-	-
Өмнөх үеийн үр дүн	1,577,708.9	1,446,722.2	(130,986.7)	(9.1)
Тайлант үеийн үр дүн	(130,986.6)	24,336.1	155,322.7	638.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,043,171.9	1,043,171.9	-	-
Дүн	3,744,762.9	3,781,404.1	36,641.2	0.9

Эх сурвалж: Хушаат сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого буюу Мянганы сорилын сангийн эх үүсвэрийн зээлээр хийгдсэн худгийн эргэн төлөлт 2,910.6 мянган төгрөг, ЭМТ-ийн эмийн сангийн орлого 27,990.0 мянган төгрөг, нийт 30,900.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой **37,729.9** мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

ТТЗ :

- Өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс бэлчээрийн төлбөрийг төсвийн орлогод төвлөрүүлэлгүйгээр Мөнх толгойн хөгжил сангийн арилжааны банкин дахь харилцах дансаар 4,790.0 мянган төгрөг, Даагат хөгжил сангийн арилжааны банк дахь харилцах дансаар 4,291.2 мянган төгрөг зэрэг нийт **9,081.2** мянган төгрөгийг төвлөрүүлж, зарцуулсан,
- Сумын онцгой комисс нь Ковид-19 цар тахалтай тэмцэхэд зориулж Монгол ангус ХХК-ийн өгсөн **5,000.0** мянган төгрөгийн хандивыг ЗДТГ-ын Төрийн банкны харилцах дансанд авсан,
- Аймгийн төсөвт тодотгол хийгдсэн гэх үндэслэлээр төсвийн төлөвлөгөөнөөс давсан орлогын эх үүсвэрээс сумын ЗДТГ-ын урсгал зардлыг *лойн менежментийн төлөвлөгөөг бусдаар гүйцэтгүүлж* **2,000.0** мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн тодотгол хийж, зарцуулсан байна.

ИТХ:

- Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс бичиг хэргийн

зардлаас **210.0** мянган төгрөгийг мэдээлэл технологийн зардлыг санхүүжүүлсэн.

ЗДТГ:

- Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний хураамжийн зардлаас **211.0** мянган төгрөгийг багаж техник хэрэгслийн зардлыг санхүүжүүлсэн,
- ЗДТГ нь малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх эргүүл хийх болон байгууллагын албан хэрэгцээнд ашигласан автомашинуудын зарцуулах нормд хэмжилт, сорилт хийж шинэчлэн тогтоолгүйгээр 100 км-т 2.5-13.6 литрээр илүү зарцуулахаар тооцоолж **2,362.8** мянган төгрөг /аудитын түүвэрээр/-ийн шатахууныг илүү олгосон байна.

Цэцэрлэг:

- Дээд шатны төсвийн захирагчийн тушаал шийдвэргүйгээр Ж.Сувд-Эрдэнэд **658.7** мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон,
- Сахилгын шийтгэл ногдуулсан багш, албан хаагчдад сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад **931.7** мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон,
- НД тайланд **1,261.8** мянган төгрөгийн цалинг илүү тайлагнасан байна.

ЕБС:

- Дээд шатны төсвийн захирагчийн тушаал шийдвэргүйгээр захирал Э.Ариунаад **826.5** мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл, ээлжийн амралтын олговортой давхардуулан 3 хонгийн цалин илүү олгосон,
- Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас илүү цагийн хөлсийг буруу тооцож, Ц.Цэцэгмаад **140.2** мянган төгрөгийн цалин илүү олгосон байна.

ЭМТ:

- Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын 4,751.0 мянган төгрөгийн орлого, эмийн сангийн 9,900.0 мянган төгрөгийн кассын орлого, зэрэг нийт **14,651.0** мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд орлого орсон тухай бүр бус жилд нийт 29 удаа бөөн дүнгээр төвлөрүүлсэн,
- Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс ЭМТ нь бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас **395.0** мянган төгрөгийг гэрэл цахилгааны зардлыг санхүүжүүлсэн.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн

5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Сумын ИТХ-ын 2021 оны 11 сарын 15-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор “Хушаат сумын 2021 оны тодотгосон төсөв” баталж, тайлант оны татварын орлогыг 60,898.5 мянган төгрөгөөр, татварын бус орлогыг 24,660.4 мянган төгрөгөөр, нийт 85,558.8 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 163,894.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 91.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/				
Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	60,898.5	130,989.1	70,090.9	214.9
Үйл ажиллагааны орлого	16,906.3	18,464.7	1,558.4	109.2
Хөрөнгийн орлого	13,614.1	13,199.6	(414.5)	97.0
Хөрөнгө борлуулсны орлого	3,434.0	5,519.4	2,085.4	160.7
Бууны албан татвар	810.0	1,320.0	510.0	163.0
Малд ногдуулах албан татвар	-	63,320.2	63,320.2	-
Улсын тэмдэгтийн хураамж	2,529.0	2,644.6	115.6	104.6
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	786.5	262.1	(524.4)	33.3
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2,748.4	2,880.4	132.0	104.8
Газрын төлбөр	8,326.9	10,055.1	1,728.2	120.8
Дуудлага худалдаа	96.0	96.0	-	100.0
Ойн нөөц ашигласны төлбөр	6,248.1	7,389.7	1,141.6	118.3
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1,256.0	1,316.0	60.0	104.8
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	4,143.2	4,521.3	378.1	109.1
Татварын бус орлого	24,660.4	32,905.8	8,245.4	133.4
Торгуулийн орлого	35.0	1,408.1	1,373.1	4,023.1
Бусад орлого	24,625.4	31,497.7	6,872.3	127.9
Нийт орлогын дүн	85,558.9	163,894.9	78,336.0	191.6

Эх сурвалж: Хушаат сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд үйл ажиллагааны орлого 1,558.4 мянган төгрөг, хөрөнгө борлуулсны орлого 2,085.4 мянган төгрөг, газрын төлбөр 1,728.2 мянган төгрөг, ойн нөөц ашигласны төлбөр 1,141.6 мянган төгрөгөөр давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- Үйл ажиллагааны орлого: Тайлант онд хувиараа хадлан бэлтгэгчдийн өвсний борлуулалт нэмэгдэж, хувь хүний орлогын албан татвар төлснөөс шалтгаалсан,

- Хөрөнгө борлуулсны орлого: Иргэдийн эзэмшиж, өмчилж буй газар болон үл хөдлөх хөрөнгийн борлуулалт төлөвлөсөн хэмжээнээс нэмэгдсэнээс шалтгаалсан,
 - Бууны албан татвар: Өмнөх онд төлүүлэхээр ногдуулсан албан татварын орлогыг тайлант онд төвлөрүүлсэн,
 - Малд ногдуулах албан татвар: Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд тус албан татварын төлөвлөгөөг сумын төсөвт батлаагүй боловч 63,320.2 мянган төгрөгийн орлого төвлөрсөн,
 - Улсын тэмдэгтийн хураамж: Иргэдийн бичиг баримтыг баталгаажуулах нотариатын төлбөр болон газрын гэрчилгээний тэмдэгтийн хураамжийн орлого нэмэгдсэнээс шалтгаалсан,
 - Хог хаягдлын үйлчилгээний хураамж: ЗГ-ын 2020 оны 211 дүгээр тогтоолоор Айл өрхийн энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төрөөс хариуцан төлөх болсноос шалтгаалж тус хураамжийн төлөвлөгөөг багаар баталж, өмнөх оны төлөгдөөгүй үлдэгдлийг төвлөрүүлснээс шалтгаалсан,
 - Газрын төлбөр: Төлөвлөсөн орлого төлөвлөгөөнөөс давж биелсэн,
 - Ойн нөөц ашигласны төлбөр: Өмнөх онуудад олгосон хэрэглээний модны зөвшөөрлийн төлбөрийг иргэдээс авч төвлөрүүлсэн,
 - Ан амьтны нөөц ашигласны төлбөр: Сумын төсвийн орлогыг гүйцэтгэлээр батлуулснаас хойш зэрлэг гахай агнах зөвшөөрөл нэмж олгосноос шалтгаалсан,
 - Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр: Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгөгдсөн бэлчээрийн төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж байх албан шаардлагыг хэрэгжүүлж эхэлснээс шалтгаалсан,
 - Торгуулийн орлого: Татварын улсын байцаагчийн ногдуулсан торгуулийн төлбөр нэмэгдсэнээс шалтгаалсан,
 - Бусад орлого: Зөрчлийн тухай хуулийн хүрээнд ногдуулсан торгуулийн орлого төлөвлөснөөс давж нэр заагдаагүй орлогын дансанд төвлөрснөөс давж биелсэн.

Тасарсан орлого:

- Хөрөнгийн орлого: Арилжааны банкууд иргэдийн банкин дахь харилцах, хугацаагүй хадгаламжид хүү олгохгүй болсноос шалтгаалж хүүгийн орлого төлөвлөснөөс багаар төвлөрснөөс шалтгаалсан,
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр: Суманд зам арчлалттай холбоотойгоор уг төлбөрийг төлөвлөсөн боловч замын ажил бүрэн хийгдээгүйтэй холбоотойгоор төлөвлөгөө тасарсан байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,218,278.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,218,278.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2020 оны 07 дугаар тогтоолоор төсвийн орлогыг 73,881.1 мянган төгрөг, эхний үлдэгдлээс санхүүжих 14,152.2 мянган төгрөг, аймгийн төсвөөс

олгох санхүүгийн дэмжлэгийг 575,595.5 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 81,937.3 мянган төгрөг, ТЗШ-ийн байгууллагын санхүүжилтийг 1,026,142.8 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 143,214.7 мянган төгрөг зэрэг нийт 1,914,923.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 16 дугаар тогтоолоор аймгийн 2021 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор татварын болон татварын бус орлогоос 85,558.9 мянган төгрөг, эхний үлдэгдлээс 14,152.2 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 580,595.5 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгээс 81,937.3 мянган төгрөг, ТЗШ-ийн байгууллагын санхүүжилтээс 1,104,405.0 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 143,214.7 мянган төгрөг зэрэг нийт **2,009,863.6** мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр эцэслэн баталсан байна.

Үүнээс ТЗШ-ийн байгууллагуудад 1,104.405.0 мянган төгрөг, орон нугийн төсвөөс ТЗШ-ийн байгууллагуудад 163,736.1, ИТХ-д 47,881.7 мянган төгрөг, ЗДТГ-д 363,106.9 мянган төгрөг, соёлын төвд 105,581.9 мянган төгрөг, ОНХС-д 81,937.3 мянган төгрөг, СХС-ийн зээлд 143,214.7 мянган төгрөгийн зэрэг нийт **2,009,863.6** мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 2,009,863.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,774,140.8 мянган төгрөгийг урсгал зардалд, 92,508.10 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, СХС-ийн зээлд 143,214.7 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр ТЗШ-ийн байгууллагуудын санхүүжилт 1080,898.9 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 580,595.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс **163,894.9** мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 14,152.2 мянган төгрөг, ОНХС-аас 81,937.3 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 33,325.4 мянган төгрөг, ЭМ-ийн даатгалын сангаас 2,539.9 зэрэг нийт 1,957,185.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,824,130.4 мянган төгрөг буюу 90.4 хувьтай тайлагнагдсан нь СХС-аас тайлант онд зээл олгоогүй, ТЗШ болон орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн болон харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлтээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 20,658.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3,672.3 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 43.5 мянган төгрөгөөр, нормативт зардал 15,355.5 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 112.3 мянган төгрөгөөр, томилолтын зардал 333.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,045.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 19,933.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 5 төсөл, арга хэмжээнд 81,937.3 мянган төгрөгийн санхүүжилт батлагдаж, бүрэн зарцуулагдсан байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчдын 57,2,392.2 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 5,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 30,900.6 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 56,966.8 мянган төгрөг зэрэг нийт 150,259.6 мянган төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 17,129.7 мянган төгрөг, НДШ-д 2,143.8 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 6,463.6 мянган төгрөг, нормативт зардалд 53,102.1 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 4,923.0 мянган төгрөг, томилолт, зочны зардалд 288.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 599.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 35,004.7 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 30,605.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Хушаат сумын ЭМТ нь 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн МБ-ТМЦ-21-010 дугаар “Эмнэлгийн тоног төхөөрөмж худалдах, худалдан авах” гэрээг Мед буян ХХК-тай байгуулсан боловч Ковид 19 цар тархлын улмаас хилээр тоног төхөөрөмж орж ирэх боломжгүй болсноос шалтгаалж тайлант онд 14,750.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжүүдийг хүлээж аваагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх

зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 120 мэдээллийг хугацаанд нь, 32 мэдээллийг хугацаа хоцроож шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл - 4 удаа
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт - 1 удаа
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар - 3 удаа
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт - 2 удаа
- Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл - 5 удаа
- Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл - 4 удаа
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө - 1 удаа
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл - 4 удаа
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл - 1 удаа
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг - 1 удаа
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр - 2 удаа
- Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт - 2 удаа
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн - 2 удаа

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Хушаат сумын ТТЗ-ийн тайлант оны үйл ажиллагаанд 2,017,040.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,824,130.4 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 9.6 хувиар хэмнэсэн байна.

Харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлт:

- ИТХ-ын тайлант оны үйл ажиллагаанд 47,881.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 46,419.9 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 3.0 хувиар хэмнэсэн,

- ЗДТГ-ын тайлант оны үйл ажиллагаанд 363,106.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 361,958.0 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 0.3 хувиар хэмнэсэн,
- Соёлын төвийн тайлант оны үйл ажиллагаанд 105,581.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 105,017.9 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 0.5 хувиар хэмнэсэн,

Энэ нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 25,158.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 төлбөрийн акт, 5 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 8 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,706.4	1	1,706.4	-	-	100
Албан шаардлага	5	21,115.1	4	8,529.9	1	12,582.2	80
Зөвлөмж	2	2,337.1	1	2,337.1	1	-	50
Нийт	8	25,158.6	6	12,573.4	2	12,582.2	75

Эх сурвалж: Хушаат сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, Хушаат сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, холбогдох баримтууд

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

ТТЗ нь өмнөх аудитаар өгсөн сумын бэлчээрийн төлбөрийг төсвийн орлогод төвлөрүүлж, зарцуулж байх албан шаардлагыг биелүүлээгүй, тайлант онд давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй.....нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан бөгөөд харин төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, ОНХС-ийн зарцуулалтын үр дүн сэдэвт аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагчийн 6 төсвийн байгууллага, орон нутгийн төсөл, сангийн 2, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 байгууллагад дүгнэлт гаргаж, 6 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Хушаат сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 140,858.9 мянган төгрөгийн 24 алдаа, зөрчил илрүүлснээс 15,786.9 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 2,557.1 мянган төгрөгийн зөрчилд 4 зөрчилд төлбөрийн акт тогтоон, 32,046.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 6 зөрчилд албан шаардлага, 90,468.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитад хамрагдсан харьяа 2 байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

ТТЗ-ийн түвшний аудитаар нийт 90,785.5 мянган төгрөгийн 14 алдаа, зөрчил илрүүлснээс 15,786.9 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 30,216.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 6 зөрчилд албан шаардлага, 44,782.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа:

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тайлагналын алдаатай 15,786.9 мянган төгрөгийн залруулгыг санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- СХС-ийн тайланд 805.7 мянган төгрөгийн орлогыг илүү тайлагнасныг үр дүнгийн тайланд залруулж тусгуулсан,
- ЭМТ нь Мед буян ХХК-иас хүлээн аваагүй 14,750.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгө дансанд бүртгэж, санхүүгийн байдлын тайланд тусгасан байсныг авлагаар тусгуулж залруулсан,
- ЭМТ нь тайлант онд акталсан 231.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаар тайлагнасан байсныг аудитын явцад залруулж залруулсан алдаагаар бүртгэв.

4.2 Албан шаардлага

1. Тайлант онд бэлчээрийн төлбөрийг төсвийн орлогод төвлөрүүлэлгүйгээр Мөнх толгойн хөгжил сангийн арилжааны банк дахь харилцах дансаар 4,790.0 мянган төгрөг, Даагат хөгжил сангийн арилжааны банк дахь харилцах дансаар 4,291.2 мянган төгрөг зэрэг нийт **9,081.2** мянган төгрөгийг төвлөрүүлж, зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь “Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ: 23.8.6: байгалийн ургамал ашигласны төлбөр” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бэлчээрийн төлбөрийг тухай бүр төсвийн орлогод төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

2. Сумын онцгой комисс нь Ковид-19 цар тахалтай тэмцэхэд зориулж Монгол ангус ХХК-иас хандивласан 5,000.0 мянган төгрөгийг ЗДТГ-ын Төрийн банкин дахь жижиг мөнгөн сангийн дансанд төвлөрүүлсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь “Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно: 25.2.1.эмнэлгийн үйлчилгээ; 25.2.2.бүх шатны боловсролын үйлчилгээ; 25.2.3.соёлын үйлчилгээ” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хандив, тусламжийг Төсвийн тухай хуульд заасны дагуу төвлөрүүлж, зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

3. ЭМТ нь төсвийг зохистой удирдаагүй өглөг, авлага ба төлбөрийн тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 1,253.1 мянган төгрөгийн цалингийн авлага, 230.7 мянган төгрөгийн эмийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог **хянах**, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

4. ЭМТ нь Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын 4,751.0 мянган төгрөгийн, эмийн сангийн 9,900.0 мянган төгрөгийн зэрэг нийт **14,651.0** мянган төгрөгийн кассын орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд орлого орсон тухай бүр бус бөөн дүнгээр төвлөрүүлсэн нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1-р хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 3.12 дахь “Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан

тасалбараас өөрт үлдэх хувь) тооцоог гаргаж, тайланг тушаана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Кассын орлогыг тухай бүр нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

5. Өмнөх аудитаар өгсөн сумын бэлчээрийн төлбөрийг төсвийн орлогод төвлөрүүлж, зарцуулж байх албан шаардлагыг биелүүлээгүй, тайлант онд давтан гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан сумын Санхүүгийн албаны дарга О.Цогбаярт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэх.

4.3 Зөвлөмж

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 44,782.6 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн тодотголттой холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Аймгийн төсөвт тодотгол хийгдсэн гэх үндэслэлээр төсвийн төлөвлөгөөнөөс давсан орлогын эх үүсвэрээс сумын ЗДТГ-ын урсгал зардлыг /ойн менежментийн төлөвлөгөөг бусдаар гүйцэтгүүлж/ 2,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн тодотгол хийж, зарцуулсан байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Уг зөрчил нь Төсвийн тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.2 дахь “Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ”, 34.2.2: “Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон” гэсэн заалтуудыг зөрчсөн тул зайлшгүй нөхцөл бий болоогүй байхад байгууллагуудын урсгал болон хөрөнгийн зардлыг санхүүжүүлэхээр төсөвт тодотгол хийхгүй байх.

2. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс ИТХ нь бичиг хэргийн зардлаас 210.0 мянган төгрөгийг мэдээлэл технологийн зардалд, ЗДТГ нь бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний хураамжийн зардлаас 211.0 мянган төгрөгийг багаж техник хэрэгслийн зардалд, ЭМТ нь бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 395.0 мянган төгрөгийг гэрэл цахилгааны зардалд зэрэг нийт **816.0** мянган төгрөгийг тус тус санхүүжүүлсэн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж

мэдэгдлийг зөрчиж байгаа тул зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлж байх.

3. Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Тайлант онд ИТХ нь 2,473.0 мянган төгрөгийн, ЗДТГ нь 21,327.4 мянган төгрөгийн, Соёлын төв нь 3,752.4 мянган төгрөгийн, ЭМТ нь 12,051.0 мянган төгрөгийн зэрэг нийт **39,603.8** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид холбогдох хууль тогтоомжийн дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

4. Зардлын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: ЗДТГ нь малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх эргүүл хийх болон байгууллагын албан хэрэгцээнд ашигласан автомашинуудын шатахуун зарцуулах нормд хэмжилт, сорилт хийж шинэчлэн тогтоолгүйгээр 100 км-т 2.5-13.6 литрээр илүү зарцуулахаар тооцоолж 2,362.8 мянган төгрөг /аудитын түүврээр/-ийн шатахууныг илүү олгосон байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”, 3 дугаар хавсралтаар батлагдсан “Автомашин шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж, жишээ”-г зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна. Цаашид автомашины шатахууны нормыг бодитоор тогтоон, мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байг уул агын нэр	Аудитын код	Зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Үүнээс		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
																Тоо
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1			Бэлчээрийн төлбөрийг төсвийн орлогод төвлөрүүлэлгүйгээр 2 багийн хөгжлийн санд төвлөрүүлж, зарцуулсан	1	9,081.2					1	9,081.2					
2			Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад ЗДТГ-ын урсгал зардлыг санхүүжүүлэхээр төсөвт тодотгол хийсэн	1	2,000.0									1	2,000.0	
3			Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүй	1	816.0									1	816.0	
4	ТТЗ	СЭА-2022/15-НА-СТА-ТТЗ	Сумын онцгой комисс нь ЗДТГ-ын арилжааны банк дахь харилцах дансанд хандив авсан	1	5,000.0					1	5,000.0					
5			Өмнөх аудитаар өгсөн сумын бэлчээрийн төлбөрийг төсвийн орлогод төвлөрүүлж, зарцуулж байх албан шаардлагыг биелүүлээгүй, тайлант онд давтан гаргасан байна.	1	-								1	-		
6			Тайлант онд харьяа байгууллагууд бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй	1	39,603.8										1	39,603.8

Хушаат сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

7	ЗДТГ	СЭА-2022/15-НА-СТА-ТТЗ	Шатахууны нормативыг баримтлаагүйгээс зарүүтэй олгосон	1	2,362.8												1	2,362.8
8			Хүлээн аваагүй тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн	1	14,750.0	1	14,750.0											
9		СЭА-2022/15-НА-СТА-ТТЗ	Акталсан бараа материалыг зарцуулснаар тайлагнасан	1	231.2	1	231.2											
10	ЭМТ	СЭА-2022/15-НА-СТА-ТТЗ	Төсвийг зохистой удирдаагүйгээс өглөг, авлага үүсгэсэн	1	1,483.8			1	1,483.8									
11			Кассын орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд орлого орсон тухай бүр төвлөрүүлээгүй	1	14,651.0			1	14,651.0									
12	СХС	СЭА-2022/15-НА-СТА-ТТЗ	Үр дүнгийн тайланд орлого илүү тайлагнасан	1	805.7	1	805.7											
				12	90,785.5	3	15,786.9	-	-	-	4	30,216.0	1	-	4	44,782.6		
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																		
1	ТТЗ	СЭА-2022/15-НА-СТА-ТТЗ	Шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллээс 32-ыг хугацаа хоцроож мэдээлсэн	1													1	-
			ТТЗ-ийн тайлант оны үйл ажиллагаанд 2,017,040.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,824,130.4 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 9.6 хувиар хэмнэсэн	1													1	-
				2													2	-
НИЙТ ДҮН				14	90,785.5	3	15,786.9	-	-	-	6	30,216.0	1	-	4	44,782.6		